

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/076/НА-СТА-ОНӨТҮГ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор	Г.Нандинжаргал
	Утас: 70077734	Цахим хаяг: Nandinjargalg@audit.gov.mn
Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	Х.Түвшинбаяр
	Утас: 327734	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Н.Бадамхатан
	Утас: 325093	Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.05.13 № 806
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын битүүмжилсэн хөрөнгийг тоолж, хүлээлцсэн акт, ажлын тайлангүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй байхад цалингийн болон ашиглалт, түрээс, шатахууны зардалд төсвөөс санхүүжилт өгсөн, баланст бүртгэлтэй хувь хүмүүсээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 “Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Монгол улсын ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4 “тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргийн үйлдвэр\2026\076\НА-СТА-ОНӨҮГ\1426050847

1426050847

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 25/152 дугаар тогтоол, Нийслэлийн ЗД-ын 2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/77 захирамжаар Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд тусгагдсан 3,302.2 сая төгрөгийн хөрөнгийг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд балансаас баланст шилжүүлэх тухай шийдвэр гарсан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/132 дугаар тогтоолоор Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын тайлант оны зардлыг баталсан байна. Уг баталсан тогтоолоор ОНӨААТҮГ-ыг шилжүүлэн, татан буулгах, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн зардалд нийт 305,845.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудал

Нийслэлийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 25/153 дугаар тогтоолоор Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ыг Туулын хурдны зам ОНӨААТҮГ болгон өөрчилсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргэ\2026\2025\word\iywshn бичиг\Duqnet_2026.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,590.59	
1.1.2	Дансны авлага	606,653,628.20	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	553,180.50	
1.1.6	Бараа материал	297,702,842.26	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	904,930,242	-
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	788,761,850.07	
1.2.2	Биет бус хөрөнгө	30,401,600.00	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	819,163,450.07	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,724,093,691.62</u>	-
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	436,582,041.47	
2.1.1.2	Ажиллагсадтай холбоотой өглөг	23,781,911.69	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	460,363,953.16	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	460,363,953.16	-
	Эздийн өмч		
2.3	Өмч:	1,564,417,300.15	1,564,417,300.15
2.3.1	- төрийн	1,564,417,300.15	1,564,417,300.15
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	954,854,362.15	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	993,604,033.00	993,604,033.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,249,145,956.84)	(2,558,021,333.15)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,263,729,738.46	-
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>1,724,093,691.62</u>	=

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	84,361,115.66	238,932,362.55
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	84,361,115.66	238,932,362.55
4	Ерөнхий ба удирдлагын зардал	84,361,115.66	238,932,362.55
5	Бусад ашиг (алдагдал)		
6	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	-
7	Орлогын татварын зардал		
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
9	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
10	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-	-
11	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 1-р сарын 1 үлдэгдэл	1,564,417,300.2	954,854,362.2	993,604,033.0	(2,249,145,956.8)	1,263,729,738.5
Өмчид гарсан өөрчлөлт					-
2024 оны 12-р сарын 31 үлдэгдэл	1,564,417,300.2	954,854,362.2	993,604,033.0	(2,249,145,956.8)	1,263,729,738.5
2025 оны 1-р сарын 1 үлдэгдэл	1,564,417,300.2	954,854,362.2	993,604,033.0	(2,249,145,956.8)	1,263,729,738.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				1,407,940,924.4	1,407,940,924.4
Залруулсан үлдэгдэл	1,564,417,300.2	954,854,362.2	993,604,033.0	(841,205,032.4)	2,671,670,662.9
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,716,816,300.7)	(1,716,816,300.7)
Өмчид гарсан өөрчлөлт		(954,854,362.2)			(954,854,362.2)
2025 оны 12-р сарын 31 үлдэгдэл	1,564,417,300.2	-	993,604,033.0	(2,558,021,333.2)	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1			
1.1	Мөнгөн орлогын дүн	84,361,115.66	238,932,362.55
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	84,361,115.66	238,932,362.55
1.2	Мөнгөн зарлагын дүн	84,361,115.66	238,932,362.55
1.2.1	Ажиллагчдад төлсөн	58,705,062.32	62,818,162.60
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,467,500.00	4,867,584.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,991,343.34	2,711,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,680,000.00	6,153,600.00
1.2.6	Шуудан холбоо, интернэтийн үйлчилгээний төлбөрт төлсөн	396,000.00	500,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,621,210.00	6,621,210.00
1.2.9	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	1,500,000.00	
1.2.10	Бараа үйлчилгээний бусад зардал	-	155,260,805.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

д/д	Зардлын ангилал	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Ажиллагсадтай холбоотой зардал	102,618.7	67,685.7	34,933.0	66.0%
1-1.	Цалин хөлс	90,363.7	62,818.2	27,545.5	69.5%
1-2.	НДШ	12,255.0	4,867.6	7,387.4	39.7%
1-3.	ХХОАТ	-	-	-	
2	Бараа үйлчилгээний зардал	195,550.9	171,246.5	24,304.4	87.6%
2-1.	Ажлын байрны ашиглалтын зардал	624.0	468.0	156.0	75.0%
2-2.	Ажлын байрны түрээсийн зардал	7,200.0	5685.5	1,514.5	79.0%
2-3.	Бичиг хэрэг, аж ахуйн зардал	140.0	105.0	35.0	75.0%
2-4.	Тээвэр шатахуун	2,960.0	2,000.0	960.0	67.6%
2-5.	Шуудан холбоо, интернэтийн зардал	858.0	420.0	438.0	49.0%

2-6.	Хангамжийн материалын зардал	186.0	186.0	-	100.0%
2-7.	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр	9,000.0	7,121.2	1,878.8	79.1%
2-8.	Бараа үйлчилгээний зардал	174,582.9	155,260.8	19,322.1	88.9%
3	Урсгал шилжүүлэг	7,676.0	-	7,676.0	0.0%
3-1.	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,676.0	-	7,676.0	0.0%
	НИЙТ ЗАРДАЛ	305,845.6	238,932.3	66,913.3	78.1%

3. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,348,521.2 мянган төгрөгийн зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллагын үйлдвэрийн тоног төхөөрөмж, барил-гыг битүүмжилснээс хойш үйл ажиллагаа явуулаагүй байхад санхүүжилт олгосон байна.	1	238,932.4					1	238,932.4				
НЗД-ын 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн “Өр барагдуулах тухай” А/265 захирамжаар 2013 оноос хойш битүүмжлэгдсэн хөрөнгийг хүлээж авсан ШШГГ, банк болон бусад ажлын хэсгийн акт зэрэг анхан шатны баримтууд байхгүй байна.	1	1,109,588.8					1	1,109,588.8				
	2	1,348,521.2					2	1,348,521.2				